



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 96

Номгон

Алтны худалдаа эрхлэгчдийн бүртгэл,  
мэдээллийн санг бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Аймгийн алтны худалдаа эрхлэгчдийн гаргасан хүсэлт, алтны худалдаа эрхлэх нэрийдлээр гаднаас орж ирж буй иргэн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, цаашлаад татвараас зайлсхийх, алт зуучлагчдын хууль бус далд наймааг зогсоох зорилгоор аймгийн алтны худалдаа эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийн санг бий болгосугай.

2. Бүртгэл мэдээллийн санд шинээр бүртгүүлэх иргэн аж ахуйн нэгжүүдэд тавигдах шаардлагын талаар журам боловсруулан баталж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга /Ж.Мөнхсоёл/-д даалгасугай.

3.Тогтоол батлагдсантай холбогдуулан дээрх үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Ц.Анхбаяр/, Мэргэжлийн хяналтын газар /Н.Бямбадорж/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Бат-Өлзий/, Стандарт, хэмжилзүйн хэлтэс /М.Хосбаяр/ нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190146